САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

## 2015 ОНЫ III УЛИРАЛ

**(Ажлын баримт)**

## Ажлын баримт – Дэлгэрэнгүй хэлбэрээр

Сүүлд шинэчлэгдсэн 2015.11.20

Танилцсан:

СЗХ-НЫ ДАРГА З.НАРАНТУЯА ________________________

СЗХ-НЫ ДЭД ДАРГА Х.БУМ-ЭРДЭНЭ ________________________

СЗХ-НЫ ДЭД ДАРГА Э.БАТБОЛД ________________________

Хянасан:

СЗХ-НЫ АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Б.БАТСЭЛЭНГЭ ________________________

ҮЦЗГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Т.ГАНДУЛАМ ________________________

ҮЦЗГ-ЫН ОРЛОГЧ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.ТУЛГАА ________________________

ҮЦЗГ-ЫН ҮЦБХ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЭНХБАТ ________________________

Боловсруулсан:

ҮЦЗГ-ЫН ҮЦБХ-ЫН ХЯНАН

ШАЛГАГЧ А.ДАВААЖАВ ________________________

# I. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Үнэт цаасны зах зээл нь олон нийтээс санхүүжилт босгохоор хувьцаа, өрийн хэрэгслээ мэргэжлийн зуучлагчаар дамжуулан зах зээлд гаргадаг нийлүүлэлтийн тал, ногдол ашиг болон ханшны зөрүүнээс ашиг олох зорилго бүхий хөрөнгө оруулагч буюу эрэлтийн тал, эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангаж, үнэ ханшийг тогтоох үүрэг бүхий дэд бүтцээс бүрддэг нийлмэл тогтолцоо.

Мөн дэд бүтцийн байгууллагуудын хоорондын уялдааг хангах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, нэгдсэн бодлого, дүрэм журмаар зохицуулах чиг үүргийг төрийн зохицуулагч байгууллага хэрэгжүүлдэг ба олон нийтийн болон хөрөнгө оруулагчийн боловсролыг дээшлүүлэх нь мөн тэргүүлэх чиглэлийн нэг болоод байгаа билээ.

Манай улсын үнэт цаасны зах зээл үүсэн бий болоод даруй 20 жилийн нүүрийг үзсэн боловч дэд бүтцийн байгууллагуудын уялдаа сул, өмч хувьчлалын арга хэрэгсэл хэлбэрээр анхлан үүссэн тул компанийн засаглал сул, мэдээлэл, тайлагналын ил тод байдлын тогтолцоо бүрдээгүй, бирж дээр арилжаалагдах бүтээгдэхүүний нэр төрөл цөөн байгаагаас арилжааний нийт хэмжээ бага бага байна.

Иймд салбарын зохицуулагч байгууллага болон арилжаа эрхлэгч байгууллагын зүгээс зах зээлд шинэ бүтээгдэхүүн гаргах, дотоодын компаниудыг гадны болон дотоодын биржид давхар бүртгэл (dual listing)-тэй болгох талаар холбогдох судалгааны ажлуудыг хийж, засаглалыг сайжруулах, мэдээлэл, тайлагналын ил тод байдлыг хангуулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллаж байна.

## 1.1.Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн болон үндсэн үзүүлэлтүүд: Хөрвөх чадвар, зах зээлийн үнэлгээ:

Хөрвөх чадварын түвшин нь зах зээлд арилжигдаж буй үнэт цаасны эргэлтийг хэмжигч үзүүлэлт бөгөөд хөгжингүй зах зээлтэй орнуудын хувьд дээрх үзүүлэлт 0.80-0.90 хувь байдаг ба манай орны хувьд хөрвөх чадварын түвшин 0.005 хувь байгаа нь хувьцааны арилжаа зогсонги, эргэцгүй байгааг илтгэж байна.

Хүснэгт-1

| Огноо | Зах зээлийн үнэлгээ /сая ₮/ | ДНБ /сая ₮/ | ЗЗҮ/ДНБ /хувиар/ | Хөрвөх чадвар | Арилжааны хэмжээ /сая ₮/ |
|---|---|---|---|---|---|
| **2008** | 515,872.4 | 6,130,325.5 | 8.42 | 0.001 | 62,346.1 |
| **2009** | 620,705.7 | 6,055,794.3 | 10.25 | 0.001 | 23,181.5 |
| **2010** | 1,373,946.2 | 8,414,504.6 | 16.33 | 0.006 | 92,873.1 |
| **2011** | 2,168,570.0 | 10,829,689.6 | 20.02 | 0.004 | 350,235.9 |
| **2012** | 1,799,898.9 | 13,944,238.1 | 12.91 | 0.001 | 145,056.7 |
| **2013** | 1,670,531.2 | 15,870,046.4 | 10.53 | 0.002 | 98,597.2 |
| **2014** | 1,442,655.0 | 21,844,250.3 | 6.60 | 0.042 | 60,358.7 |
| **2015/3nd Q** | 1,289,804.96 | 16,834,126.8 | 0.04 | 0.005 | 7,032.2 |

Мөн хөрвөх чадварын түвшинг бага байхад голчлон хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын хяналтын багц цөөн тооны хувьцаа эзэмшигч нарын гарт төвлөрсөн, нийт бүртгэлтэй компаниудын дийлэнх нь 75 хувиас дээш төвлөрөлтэй, нэмж үнэт цаас гаргах сонирхол бага, гадаад, дотоодын томоохон мэргэжлийн хөрөнгө оруулагч байхгүй, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл дутмаг, хөрөнгийн бирж дээр маркет макерийн зуучлалын тогтолцоо хөгжөөгүй нь суурь нөлөөг үүсгэжээ. Мөн мэргэжлийн зуучлагч байгууллагуудын санхүүгийн болон хүний нөөцийн чадавхи сул, маржин арилжаа буюу зээлээр үнэт цаас худалдан, худалдан авах үйлчилгээний төрөл хөгжөөгүй байгаа зэрэг нь хөрвөх чадварын түвшинг бага байхад давхар нөлөөлсөөр байна.

Зах зээлийн үнэлгээг 2014 оны эцэстэй харьцуулахад 152.8 тэрбум төгрөгөөр буюу 10.6 хувиар буурч, 1 их наяд 289.8 тэрбум төгрөг болсон байна. Нийт зах зээлийн үнэлгээг өмнөх онуудтай харьцуулан дараах графикаар харуулав.

График-1




Нийт зах зээлийн үнэлгээ буурахад манай орны эдийн засгийн өсөлт буурсан, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг компанийн хувьцааны үнэ ханш дотоодын болон олон улсын хөрөнгийн бирж дээр огцом унасан, нийт эдийн засагт гадаадын хөрөнгө оруулалт буурсан болон үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхол 2012 оноос хойш буурах хандлагатай байгаа, зах зээлийн дэд бүтэц сул байгаа зэрэг нь голчлон нөлөөлж байна.

### *Хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй 30 компани*

“Монголын хөрөнгийн бирж” ХК-нд бүртгэлтэй, хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй 30 компанийг жагсаавал дараах байдалтай байх ба нийт зах зээлийн үнэлгээний 88.19 хувийг эзэлж байна. Үүнд:

Хүснэгт-2

| № | Үнэт цаасны нэр | Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/ |
|---|---|---|
| 1 | АПУ | 267.29 |
| 2 | ТАВАН ТОЛГОЙ | 194.86 |
| 3 | ГОВЬ | 68.38 |
| 4 | БАГАНУУР | 58.73 |
| 5 | ШИВЭЭ ОВОО | 56.36 |
| 6 | БЭРХ УУЛ | 53.37 |
| 7 | ШАРЫН ГОЛ | 43.36 |
| 8 | МОНГОЛ СЕКЮРИТИЕС | 36.00 |
| 9 | УБ-БҮК | 33.85 |
| 10 | СҮҮ | 33.71 |
| 11 | БИ ДИ СЕК | 28.05 |
| 12 | ГУТАЛ | 27.52 |
| 13 | МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО | 23.29 |
| 14 | УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР | 20.61 |
| 15 | ДАРХАН НЭХИЙ | 20.45 |
| 16 | БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ | 20.22 |
| 17 | ТАХЬ-КО | 18.92 |
| 18 | ТАЛХ ЧИХЭР | 18.43 |
| 19 | МАТЕРИАЛИМПЕКС | 15.60 |
| 20 | МАХИМПЕКС | 12.16 |
| 21 | АТАР-ӨРГӨӨ | 11.84 |
| 22 | СИЛИКАТ | 10.43 |
| 23 | ГЕРМЕС ЦЕНТР | 10.21 |
| 24 | ХӨХ ГАН | 9.12 |
| 25 | ЖЕНКО ТУР БЮРО | 8.30 |
| 26 | АРИГ ГАЛ | 8.07 |
| 27 | АВТО ИМПЕКС | 7.75 |
| 28 | ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП | 7.28 |
| 29 | МОНГОЛ ШИЛТГЭЭН | 6.90 |
| 30 | МОГОЙН ГОЛ | 6.43 |
| | **Нийт** | **1,137.50** |
| | **Нийтэд эзлэх хувь** | **88.19** |

График-2




## Нийт арилжаа:

“Монголын хөрөнгийн бирж” ХК-иар 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 188 удаагийн арилжаа явагдаж, 115 компанийн 20.1 сая ширхэг хувьцааг 7.03 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн 38 удаагийн арилжаагаар 4.2 сая ширхэг үнэт цаасыг 403.47 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 28.1 мянган ширхэг үнэт цаасыг 2.76 тэрбум төгрөгөөр, мөн компанийн бондын анхдагч зах зээлийн арилжаагаар 50.0 мянган ширхэг бондыг 500.0 сая төгрөгөөр тус тус арилжиж, нийт 413.76 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.

Мөн хугацаанд хийгдсэн нийт гүйлгээний 1.70%-ийг хувьцааны, 98.18%-ийг ЗГҮЦ-ны, 0.12 хувийг компанийн бондын арилжааны үнийн дүн тус тус эзэлж байна. Үүнийг хүснэгт-3 болон график-3-аар харуулав.

Хүснэгт 3.

| Үнэт цаасны төрөл | | Хийгдсэн арилжааны тоо | Арилжигдсан тоо хэмжээ /сая ширхэг/ | Арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/ |
|---|---|---|---|---|
| Хувьцаа | Энгийн | 115 | 9.1 | 5.50 |
| | Багц | | 11.1 | 1.53 |
| ЗГҮЦ | Анхдагч | 38 | 4.2 | 403.47 |
| | Хоёрдогч | | 0.03 | 2.76 |
| Компанийн бонд | Анхдагч | 1 | 0.05 | 0.5 |
| | Хоёрдогч | | | |
| **Нийт** | | 154 | 24.48 | **413.76** |

График-3



Тайлант хугацаанд өдөрт дунджаар 2.20 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 129.9 мянган ширхэг үнэт цаас арилжигдсан байна.

Арилжаалагдсан үнэт цаасны үнийн дүн болон тоо ширхэгийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан харуулбал:

Хүснэгт 4.

| Арилжааны үзүүлэлтүүд | 2014 оны 9 сарын 30 | 2015 оны 9 сарын 30 | Өөрчлөлт | Өөрчлөлт /хувиар/ |
|---|---|---|---|---|
| Арилжигдсан үнэт цаасны тоо хэмжээ /сая ширхэг/ | 40.77 | 24.43 | **-16.34** | **-40.07%** |
| Үнийн дүн /тэрбум төгрөг/ | 16.91 | 413.76 | **+396.85** | **+24.46 дахин** |

Арилжааны хэмжээг өмнөх онуудын мөн үетэй харьцуулбал нийт арилжааны үнийн дүн 2013 оноос 20.6 дахин, 2014 оноос 24.46 дахин өссөн үзүүлэлттэй байна. Ийнхүү арилжааны үнийн дүн өсөхөд ЗГЖҮЦ-ны арилжааг "Монголын хөрөнгийн бирж" ХК-иар явуулах болсон нь нөлөөлж, үнэт цаасны арилжаанд сэргэлт авчирчээ.

График-4




## Хувьцааны арилжаа:

"Монголын хөрөнгийн бирж" ХК 2015 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар нийт 188 удаагийн хувьцааны арилжаа явагдаж, нийтдээ 115 компанийн 20.1 сая ширхэг хувьцааг 7.03 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна. Хувьцааны арилжааны 21.80% буюу 1.53 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, үлдэх 78.20% буюу 5.50 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт-5

| **Үнэт цаасны нэр** | **Арилжааны үнийн дүн** /тэрбум төгрөг/ | | | |
|---|---|---|---|---|
| | 2014.09.30 | | 2015.09.30 | |
| | энгийн | багцын | энгийн | багцын |
| Хувьцаа | 9.22 | 7.69 | 5.50 | 1.53 |

Хувьцааны анхдагч зах зээлийн арилжаагаар "БиДиСек" ХК-ийн нэмж гаргасан 6.0 сая ширхэг хувьцаанаас 189 ширхэг хувьцааг 405.89 мянган төгрөгөөр, "Бинсэ" ХК-ийн нэмж гаргасан 1.0 сая ширхэг хувьцаанаас 150.8 мянган ширхэг хувьцааг 112.20 сая төгрөгөөр тус тус арилжсан байна.

Дараах график болон хүснэгтээр хувьцааны арилжааны үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулав.

**Хувьцааны арилжаа сараар /үнийн дүн/**

График-5




Хүснэгт-6

| № | Он | Арилжигдсан үнийн дүн |
|---|---|---|
| **1** | 2011 оны III улирал | 61,013,026,616.0 |
| **2** | 2012 оны III улирал | 142,540,132,227.4 |
| **3** | 2013 оны III улирал | 19,023,597,963.3 |
| **4** | 2014 оны III улирал | 16,913,248,782.6 |
| **5** | 2015 оны III улирал | 7,032,235,189.8 |

"Монголын хөрөнгийн бирж" ХК дээрх нийт хувьцааны арилжаа 2015 оны 3 дугаар улирлын байдлаар 2013 оны мөн үетэй харьцуулахад 2.7 дахин буюу 11.9 тэрбум төгрөгөөр, 2014 оны мөн үетэй харьцуулахад 2.4 дахин буюу 9.8 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Хувьцааны арилжааны хэмжээ өмнөх онуудаас эрс буурахад голчлон гадаадын иргэн, аж ахуйн нэгжүүд манай орны бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцааг худалдан авах сонирхол буурсан, дийлэнх хувьцаат компаниудын засаглал сул, төвлөрөл өндөр, тайлагналын ил тод тогтолцоо төлөвшөөгүй, зах зээлийн хөрвөх чадвар доогуур байгаа нь нөлөөлж байна.

Мөн иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, мэдээлэл хомсоос гадна хувьцаа худалдан авахаасаа илүүтэйгээр банкны хадгаламж, засгийн газрын үнэт цаасанд хөрөнгөө байршуулах сонирхол өндөр, хувьцаат компаниудын засаглалд итгэх итгэл сул байгаа нь давхар нөлөөлж байна.

Улсын бүртгэлд бүртгэлтэй байгаа дийлэнх аж ахуйн нэгжүүдийн өмчлөл нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр байгуулагдсан, гэр бүлийн бизнесийн шинжийг агуулсан, дутагдалтай байгаа санхүүжилтээ үнэт цаас гаргах замаар олон нийтээс хөрөнгө татан, төвлөрүүлэх сонирхол бага, банкны зээлийн санхүүжилтийг чухалчлах хандлага давамгайлж байна. Энэ нь анхдагч зах зээлийн арилжаа болон компанийн бондын зах зээлийг хөгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна. Санхүүгийн суурь хэрэгслүүдийн чадавхи сул байгаа нь эргээд үүсмэл санхүүгийн хэрэгсэл бий болох боломжийг багасгаж байна.

## Идэвхитэй арилжигдсан 30 үнэт цаас

Идэвхитэй арилжигдсан 30 үнэт цаасны тоо ширхэг нь нийт арилжигдсан хувьцааны тоо ширхэгийн 98.66 хувь, нийт үнийн дүнгийн 89.91 хувийг тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд 105 компанийн үнэт цаас арилжигдсан байна.

Хүснэгт-7

| ҮНЭТ ЦААС | АРИЛЖИГДСАН ШИРХЭГ | Эрэмбэ | ҮНЭТ ЦААС | ҮНИЙН ДҮН |
|---|---|---|---|---|
| Э-ТРАНС ЛОЖИСТИКС | 6,412,093 | 1 | АПУ | 816,729,776 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ХӨХ ГАН | 4,567,738 | 2 | Э-ТРАНС ЛОЖИСТИКС | 652,376,465 |
| РЕМИКОН | 2,517,373 | 3 | БИ ДИ СЕК | 610,231,403 |
| МЕРЕКС | 1,799,072 | 4 | ХӨХ ГАН | 517,545,791 |
| ХОРИН ХОЁРДУГААР БААЗ | 1,318,569 | 5 | ТАЛХ ЧИХЭР | 463,884,670 |
| ГЕРМЕС ЦЕНТР | 878,241 | 6 | ТАВАН ТОЛГОЙ | 360,432,306 |
| БИ ДИ СЕК | 348,302 | 7 | МАТЕРИАЛИМПЕКС | 358,538,950 |
| АПУ | 228,512 | 8 | ХОРИН ХОЁРДУГААР БААЗ | 270,306,645 |
| УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР | 215,009 | 9 | ГОВЬ | 247,953,225 |
| ЖЕНКО ТУР БЮРО | 174,324 | 10 | РЕМИКОН | 189,751,567 |
| ГОНИР | 160,332 | 11 | МЕРЕКС | 161,400,006 |
| ОЛЛОО | 135,514 | 12 | ГЕРМЕС ЦЕНТР | 124,016,726 |
| ӨНДӨРХААН | 91,443 | 13 | СҮҮ | 117,744,800 |
| ЖИНСТ-УВС | 90,056 | 14 | УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР | 113,503,174 |
| ТАВАН ТОЛГОЙ | 86,630 | 15 | ДАРХАН НЭХИЙ | 110,043,680 |
| ХАЙ БИ ОЙЛ | 77,798 | 16 | МОНГОЛ КЕРАМИК | 108,011,675 |
| МОНГОЛ САВХИ | 71,702 | 17 | БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ | 107,118,370 |
| БАЯЛАГ НАЛАЙХ | 64,388 | 18 | ЕВРОФЁ АЗИА | 97,394,900 |
| БИНСЭ ХК | 61,951 | 19 | ГАН ХЭРЛЭН | 82,058,830 |
| МОНИНЖБАР | 60,019 | 20 | ШАРЫН ГОЛ | 77,469,978 |
| МОНГОЛ МАХ ЭКСПО | 59,252 | 21 | МОНГОЛ САВХИ | 71,853,625 |
| БИШРЭЛТ ИНДАСТРИАЛ | 54,611 | 22 | ГУТАЛ | 71,120,900 |
| БҮТЭЭЛЧ ҮЙЛС | 38,903 | 23 | БАГАНУУР | 71,088,755 |
| ЕВРОФЁ АЗИА | 30,415 | 24 | МАХИМПЕКС | 70,931,635 |
| ГОВЬ | 30,165 | 25 | ДОРНОД АВТО ЗАМ | 64,732,500 |
| ХӨВСГӨЛ ХҮНС | 28,732 | 26 | МОНГОЛ МАХ ЭКСПО | 58,279,059 |
| БАГАНУУР | 26,619 | 27 | МОГОЙН ГОЛ | 58,258,250 |
| ТАЛХ ЧИХЭР | 25,378 | 28 | ГАЗАР СҮЛЖМЭЛ | 57,768,750 |
| ДОРНОД АВТО ЗАМ | 23,975 | 29 | УБ-БҮК | 50,126,180 |
| МАТЕРИАЛИМПЕКС | 23,368 | 30 | БИНСЭ ХК | 48,797,600 |
| Нийт | **19,700,484** | | | **6,209,470,191** |
| Нийтэд хувьцааны арилжаанд эзлэх хувь | **98.66** | | | **89.91** |

## Ханшийн өсөлттэй 20 үнэт цаас

Хүснэгт-8

| № | Үнэт цаас | Хаалтын ханш 2014.09.30 | 2015.09.30 | Ханшийн өөрчлөлт /төг/ | Өөрчлөлт хувиар |
|---|---|---|---|---|---|
| 1 | СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП | 10.00 | 46.44 | 36.44 | 364.40 |
| 2 | ТЕХНИК ИМПОРТ | 695.00 | 1,214.00 | 519.00 | 74.68 |
| 3 | ГУТАЛ | 10510 | 17000 | 6490 | 61.75 |
| 4 | ТАХЬ-КО | 11,000.00 | 15,900.00 | 4,900.00 | 44.55 |
| 5 | МОНГОЛ ШЕВРО | 2640 | 3762 | 1122 | 42.50 |
| 6 | УЛААНСАН | 1,000.00 | 1,350.00 | 350.00 | 35.00 |
| 7 | БИНСЭ ХК | 586.9 | 780 | 193.1 | 32.90 |
| 8 | МОН-ИТ БУЛИГААР | 8000 | 10000 | 2000 | 25.00 |
| 9 | ХӨСӨГ ТРЕЙД | 1,150.00 | 1,400.00 | 250.00 | 21.74 |
| 10 | МОН НАБ | 1350 | 1612 | 262 | 19.41 |
| 11 | ХӨВСГӨЛ ХҮНС | 591.15 | 680.00 | 88.85 | 15.03 |
| 12 | ХӨВСГӨЛ | 43.71 | 50.26 | 6.55 | 14.99 |
| 13 | ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ | 21.16 | 24.33 | 3.17 | 14.98 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 14 | НИЙСЛЭЛ ӨРГӨӨ | 11,350.00 | 13,000.00 | 1650 | 14.54 |
| 15 | ТАВ | 24,140.00 | 27,400.00 | 3,260.00 | 13.50 |
| 16 | ГОВЬФАЙНЕНШЛ ГРУПП | 448.7 | 509 | 60.3 | 13.44 |
| 17 | БҮТЭЭЛЧ ҮЙЛС | 917 | 1030 | 113 | 12.32 |
| 18 | ХЭРЛЭН ХИВС | 183 | 205 | 22 | 12.02 |
| 19 | ДОРНОД ХУДАЛДАА | 9,100.00 | 10,000.00 | 900 | 9.89 |
| 20 | ГОВЬ | 8000 | 8765 | 765 | 9.56 |

**Ханшийн бууралттай 20 үнэт цаас**

Хүснэгт-9

| № | Үнэт цаас | Хаалтын ханш 2014.09.30 | 2015.09.30 | Ханшийн өөрчлөлт /төг/ | Өөрчлөлт хувиар |
|---|---|---|---|---|---|
| 1 | МОНГОЛ МАХ ЭКСПО | 6,130.00 | 1,550.00 | -4,580 | -74.71 |
| 2 | БИШРЭЛТ ИНДАСТРИАЛ | 4,500.00 | 1,600.00 | -2,900 | -64.44 |
| 3 | УВС ЧАЦАРГАНА | 2,550.00 | 950.00 | -1,600 | -62.75 |
| 4 | ИХ БАРИЛГА | 11000 | 5500 | -5,500 | -50.00 |
| 5 | РЕМИКОН | 131.09 | 74.00 | -57 | -43.55 |
| 6 | ШАРЫН ГОЛ | 7150 | 4238 | -2,912 | -40.73 |
| 7 | СОР | 2,449.00 | 1,500.00 | -949 | -38.75 |
| 8 | БАЯЛАГ НАЛАЙХ | 689 | 440 | -249 | -36.14 |
| 9 | ШИВЭЭ ОВОО | 6,500.00 | 4,200.00 | -2,300 | -35.38 |
| 10 | БИ ДИ СЕК | 2,499.00 | 1650 | -849 | -33.97 |
| 11 | ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ | 800 | 550 | -250 | -31.25 |
| 12 | МАТЕРИАЛИМПЕКС | 16,510.00 | 11,400.00 | -5,110 | -30.95 |
| 13 | БЭРХ УУЛ | 4,000.00 | 2,800.00 | -1,200 | -30.00 |
| 14 | УБ-БҮК | 42840 | 30000 | -12,840 | -29.97 |
| 15 | МОГОЙН ГОЛ | 11,000.00 | 7755 | -3,245 | -29.50 |
| 16 | АГРОТЕХИМПЕКС | 2,950.00 | 2,100.00 | -850 | -28.81 |
| 17 | ЕВРОФЁ АЗИА | 3,900.00 | 2,780.00 | -1,120 | -28.72 |
| 18 | МОНИНЖБАР | 249.99 | 180.00 | -70 | -28.00 |
| 19 | МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО | 1250 | 900.39 | -350 | -27.97 |
| 20 | БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ | 2975 | 2,150.00 | -825 | -27.73 |

## Засгийн газрын үнэт цаасны арилжаа:

“Монголын хөрөнгийн бирж” ХК-иар 2014 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс ЗГҮЦ арилжигдаж эхэлснээс хойш 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хүртлэх хугацаанд нийт 439.59 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 4.6 сая ширхэг үнэт цаас анхдагч зах зээл дээр арилжигдаад байна. Мөн урт хугацаат буюу 3 болон 5 жилийн хугацаат ЗГҮЦ-ыг 2015 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн МХБ-ээр дамжуулан арилжиж эхэлсэн бөгөөд 3 болон 5 жилийн хугацаат 365 ширхэг бондыг 37.5 сая төгрөгөөр арилжаад байна.

### *Анхдагч зах зээлийн арилжаа:*

2015 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар авч үзвэл 42 удаагийн ЗГҮЦ-ны арилжаагаар нийт 4.2 сая ширхэг ЗГҮЦ-ыг 403.47 тэрбум төгрөгөөр арилжаад байна.

Тайлант хугацаанд анхдагч зах зээл дээр нийт 403.47 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжигдсанаас 12 долоо хоногтой ЗГҮЦ-ны арилжаа дийлэнхи хувийг буюу 72.15%-ийг, 28 долоо хоногтой үнэт цаас 15.47%, 52 долоо хоногтой үнэт цаас нийт арилжааны 12.37%, 3 болон 5 жилийн урт хугацаатай үнэт цаас 0.01%-ийг тус тус эзэлж байна.

“Монголын хөрөнгийн бирж” ХК дээр арилжигдаж буй ЗГҮЦ-ыг хүүгийн хэмжээ болон арилжигдсан хэмжээгээр нь авч үзвэл 12 долоо хоног буюу 3 сарын хугацаатай ЗГҮЦ-ны хүүгийн хэмжээ буурч, арилжааны хэмжээ өссөн байна.

График-6




График-7




График-8




Анхдагч зах зээлийн арилжаа эрчимтэй хөгжихгүй байгаад дараахь хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд: Үнэт цаасны зах зээлийн багтаамж бага, иргэдийн тус зах зээлд итгэх итгэл сул, илүүдэл мөнгөн хөрөнгөө банкны хадгаламжид байршуулах сонирхол өндөр, андеррайтерийн компаниудын чадавхи сул, мэргэжлийн томоохон хөрөнгө оруулагчид байхгүйгээс шалтгаалан санхүүжүүлэхээр зорьж буй хөрөнгийг бүрэн татан төвлөрүүлэх боломж хомс байна.

*Хоёрдогч зах зээлийн арилжаа:*

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр нээсэн бөгөөд тайлант хугацаанд нийт 28.1 мянган ширхэг үнэт цаас 2.76 тэрбум төгрөгөөр арилжигдсан.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг идэвхжүүлэх үүднээс 2015 оны 2 дугаар сараас эхлэн “Market makers” буюу итгэмжлэгдсэн дилерийн тогтолцоог нэвтрүүлж өнөөдрийн байдлаар нийт 4 ҮЦК итгэмжлэгдсэн дилер эрхээ авч, улмаар хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 12, 28 болон 52 долоо хоногтой 28,081 ширхэг үнэт цаас арилжиж, нийт 2.76 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаанд “Ард капитал”, “Голомт секьюритиз”, “Дэу секьюритиз”, “Гацуурт трейд”, “БиДиСек”, “Стандарт инвестмент”, “Блюмсбюри секьюритиз”, “Тэнгэр капитал” зэрэг ҮЦК-иуд идэвхитэй оролцсон байна.

**Компанийн бондын арилжаа:**

Тайлан хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК нь “Эрчим инженеринг” ХХК-иас олон нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 10,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50.0 мянган ширхэг “Эрчим” бондыг 500.0 сая төгрөгөөр арилжаалсан байна.

## Багцын арилжаа:

Тайлант хугацаанд 13 удаагийн багцын арилжаагаар нийт 13 компанийн 11.1 сая ширхэг хувьцааг 1.53 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 21.80%-ийг эзэлжээ.

## Тендер саналын арилжаа:

Тайлант хугацаанд 2 удаагийн тендер саналын арилжаа явагдаж, “Монголын хөгжил үндэсний нэгдэл" ХК-ийн 202 ширхэг хувьцааг 711.4 мянган төгрөгөөр, “Гонир” ХК-ийн 33 ширхэг хувьцааг  5.28 мянган төгрөгөөр тус тус арилжсан байна.

## Топ-20 индекс:

График-9




Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 15,737.17 нэгж,  доод үзүүлэлт 12,477.28 нэгж, дундаж үзүүлэлт 13,679.51 нэгж байна. ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,668.71 нэгжээр буюу 16.89 хувиар буурч, 13,129.04 нэгж болсон байна.

## MSE ALL индекс:

“Монголын хөрөнгийн бирж” ХК нь 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн MSE ALL индексийг албан ёсоор тооцож эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд MSE ALL индексийн дээд үзүүлэлт нь 1057.86, доод үзүүлэлт нь 921.67, дундаж үзүүлэлт 971.20 нэгж байв. 2015 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 954.21 нэгжид хүрчээ.

Тайлант хугацаанд Засгийн газрын үнэт цаасны арилжаанаас бусад үзүүлэлтүүд буурсан байх бөгөөд энэхүү бууралтад хувьцааны арилжаа хэмжээ эрс буурсан нь эргээд зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, ТОП-20 индексийн өөрчлөлтөд шууд нөлөө үзүүлсэн гэж дүгнэхээр байна. Хувьцааны арилжааны хэмжээ эрс буурахад гадаад дотоод орчны дараах хүчин зүйлс нөлөөлжээ.

График-10




**Шигтгээ-1:**

- *Гадаад болон дотоодын хөрөнгийн биржид бүртгэлтэй байгаа үндэсний уул уурхайн компаниудын хувьцааны үнэ ханшийн бууралт, хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьцааны төвлөрөл;*
- *Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон тэдгээрийн нийлүүлэлтийн дутагдал;*
- *Зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын сул байдал, хувьцаат компаниудын засаглал, мэдээллийн болон санхүүгийн тайлагналын ил тод нээлттэй тогтолцоо бүрдээгүй;*
- *Хувьцааны үнэ ханшид дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, зах зээлийг урвуулан ашиглаж нөлөөлөх хандлага өндөр;*
- *Олон нийтийн санхүүгийн болон хөрөнгө оруулалтын боловсрол сул, үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийхээсээ илүүтэйгээр банкны хадгаламжид байршуулах сонирхол өндөр.*

## 2.2. Үнэт цаас гаргагчдын бүтэц:

Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК болон “ҮЦТТТХТ” ХХК-д бүртгэлтэй үнэт цаас гаргагчдын бүтцийг үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт -10

| Үнэт цаас гаргагч компанийн хэлбэр | Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй | “Монголын хөрөнгийн бирж” ХК-нд бүртгэлтэй | “ҮЦТТТХТ” ХХК-д бүртгэлтэй |
|---|---|---|---|
| 100% Төрийн өмчийн | 32 | 21 | 19 |
| Төрийн өмчийн оролцоотой | 11 | 15 | 11 |
| Орон нутгийн оролцоотой | 15 | - | 15 |
| Хувийн өмчийн | 245 | 199 | 276 |
| **Нийт** | **303** | **235** | **321** |

Хороонд 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 303 компани бүртгэлтэйгээс 100 хувь төрийн өмчийн 32, төрийн өмчийн оролцоотой 11, орон нутгийн оролцоотой 15, хувийн өмчит 245 /үүнээс 90 хувьцаат компанийн арилжааг зогсоосон/ компани, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн бүртгэлд нийт 235 хувьцаат компани бүртгэлтэйгээс 100 хувь төрийн өмчийн 21, төрийн өмчийн оролцоотой 15, хувийн өмчит 199 компани бүртгэлтэй байгаа бол “ҮЦТТТХТ” ХХК-ийн бүртгэлд нийт 321 хувьцаат компани бүртгэлтэй байгаагаас 100 хувь төрийн өмчийн 19, төрийн өмчийн оролцоотой 11, орон нутгийн оролцоотой 15, хувийн өмчит 276 компани бүртгэлтэй байна.

### Үнэт цаас гаргагчдын хуулийн хэрэгжилтийн талаар:

Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувийн өмчит компаниудын дийлэнх хувь нь өмч хувьчлалын үр дүнд үүсэн бий болсноос үүдэн компанийн хувьцааны хяналтын багц цөөн тооны нэгдмэл

сонирхолтой этгээдүүдийн гарт төвлөрч, зах зээлийн нийлүүлэлтийн талд дутагдалтай байдал үүсгээд байна.

Хувьцаат компанийн хяналтын багц цөөн тооны этгээдүүдийн гарт төвлөрсөн нь компанийн засаглалыг сул байлгах, дотоод мэдээлэл эзэмшигч этгээд үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхлыг бууруулж, зах зээлийн хөрвөх чадварыг бууруулах үндсэн шалтгаан болж байна. 2015 оны 3 дугаар улирлын байдлаар Хороонд бүртгэлтэй 303 хувьцаат компанийн 193 компани нь 75 ба түүнээс дээш хувийн төвлөрөлтэй байна.

Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны 2012 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам" болон Хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам"-аар хувьцаат компаниудад хүлээлгэсэн үүргийн хэрэгжилтийн байдал нийт 303 ХК-ийн хувьд 2015 оны 3 дугаар улирлын байдлаар дараахи байдалтай байна.

Хүснэгт

| **Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлээ ирүүлсэн компанийн тоо** | **Санхүүгийн тайлан ирүүлсэн компанийн тоо** | **Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан компанийн тоо** | **Ногдол ашиг хуваарилсан компанийн тоо** |
|---|---|---|---|
| **НИЙТ 303 ХК** | | | |
| **145 ХК** | **173 ХК** | **133 ХК** | **23 ХК** |
| **47.85%** | **57.09%** | **43.89%** | **7.59%** |

Харин Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй нийт 303 хувьцаат компаниас үнэт цаасны арилжаа нь зогссон 90 хувьцаат компани, 100 хувь төрийн өмчийн 32, төрийн өмчийн оролцоотой 11 болон орон нутгийн оролцоотой 15 хувьцаат компанийг хасаад үлдсэн буюу "Монголын хөрөнгийн бирж" ХК-иар хувьцаа нь идэвхитэй арилжаалагддаг, хэвийн үйл ажиллагаатай 155 хувьцаат компанийн хувьд 2015 оны 3 дугаар улирлын байдлаар хуулийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 12

| **Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлээ ирүүлсэн компанийн тоо** | **Санхүүгийн тайлан ирүүлсэн компанийн тоо** | **Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан компанийн тоо** | **Ногдол ашиг хуваарилсан компанийн тоо** |
|---|---|---|---|
| **Нийт 155 ХК** | **Нийт 213 ХК** | **Нийт 155 ХК** | **Нийт 213 ХК** |
| **145 ХК /93.54%/** | **173 ХК /81.22%/** | **133 ХК /85.80%/** | **23 ХК /10.79%/** |

*Жич: Санхүүгийн тайлан ирүүлсэн тоо болон ногдол ашиг хуваарилсан компанийн тоонд зөвхөн арилжаа нь зогссон 90 хувьцаат компанийг хасаад нийт 213 компаниас хувийг тооцсон болно.*

2014 онд хувьцаа эзэмшигчдийн хурлаа зарлан хуралдуулахаар мэдэгдэл ирүүлсэн дээрх 145 хувьцаат компаниас 133 хувьцаат компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан байх бөгөөд тус Хорооны Хяналт шалгалтын газраас дээрх хувьцаат компаниудын хурлын материалыг холбогдох хууль, журмын дагуу тухай бүр хянаж, хурлын хариуг хүргүүлсэн байна.

## Үнэт цаас гаргагчдын санхүүгийн байдал:

Компанийн тухай хуулийн 95.2-д “Хувьцаат компанийн хувьд Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон нэмэлт, мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад тогтоосон хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй гэж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.6-д “хагас жилийн болон Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Хороо болон хөрөнгийн биржид хүргүүлэх” гэж тус тус заасны дагуу 173 хувьцаат компани 2015 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангаа ирүүлсэн. /Сангийн яамны санхүүгийн тайлангийн нэгтгэлийн системд ирүүлснээр/

## Нийт хөрөнгийн бүтэц:

Санхүүгийн нэгтгэлд хамрагдсан 173 хувьцаат компанийн нийт хөрөнгө нь 4,221.45 тэрбум төгрөг байх бөгөөд тайлант улирлын байдлаар мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нийт хөрөнгийн 2.43 хувийг, авлага 9.28 хувийг, татвар, бусад санхүүгийн хөрөнгө 0.36 хувийг, бараа материал 10.14 хувийг, урьдчилж төлсөн зардал 11.04 хувийг, бусад эргэлтийн хөрөнгө 0.13, бусад хөрөнгө 0.09 хувийг тус тус эзэлснээр нийт хөрөнгийн 33.47 хувийг эргэлтийн хөрөнгө эзэлсэн байна.

Харин эргэлтийн бус хөрөнгө нийт хөрөнгийн 66.53 хувийг эзэлж байх ба нийт хөрөнгийн 53.93 хувийг үндсэн хөрөнгө, 0.57 хувийг биет бус хөрөнгө, 5.75 хувийг урт хугацаат хөрөнгө оруулалт, 0.18 хувийг хайгуул ба үнэлгээний хөрөнгө, 0.22 хувийг хойшлогдсон татварын хөрөнгө, 5.87 хувийг бусад эргэлтийн бус хөрөнгө тус тус эзэлж байна.

## Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн бүтэц:

Тайлант улирлын байдлаар богино хугацаат өр төлбөр нь нийт пассивын 16.82 хувийг эзэлж байх бөгөөд бүтцээр нь харвал нийт пассивын 7.69 хувийг дансны өглөг, 0.19 хувийг цалингийн өглөг, 0.95 хувийг татварын өр, 0.35 хувийг НДШ-ийн өглөг, 3.83 хувийг банкны богино хугацаат зээл, 0.41 хувийг хүүний өглөг, 0.68 хувийг ногдол ашгийн өглөг, 1.39 хувийг урьдчилж орсон орлого, 1.34 хувийг бусад өр төлбөр тус тус эзэлж байна.

Мөн урт хугацаат өр төлбөрийн дүн нь нийт пассивын 26.19 хувийг эзэлж байх бөгөөд нийт пассивын 18.75 хувийг урт хугацаат зээл, 7.44 хувийг бусад урт хугацаат өр төлбөр тус тус эзэлж байна.

Харин эздийн өмчийн дүнгийн хувьд нийт пассивын 57.00 хувийг эзэлж байх бөгөөд дараах бүтэц байна. Нийт пассивын 17.31 хувийг төрийн хувьцаат капитал, 4.17 хувийг хувийн хувьцаат капитал, 0.01 хувийг халаасны хувьцаа, 1.45 хувийг нэмж төлөгдсөн капитал, 17.08 хувийг хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, 15.92 хувийг эздийн өмчийн бусад хэсэг, 0.54 хувийг хуримтлагдсан ашиг тус тус эзэлж байна.

## Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан компанийн тоо, бүртгэл:

Тайлант хугацаанд "Блюскай секьюритиз ҮЦК” ХК, "УБ БҮК" ХК, "БИНСЭ" ХК, "Улаанбаатар дулааны сүлжээ" ХК, "Хай Би Ойл" ХК, "ДБЭХСүлжээ" ХК, “Багануур, зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ХК, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ХК, “Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ” ХК, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ХК зэрэг хувьцаат компаниуд буюу нийт 10 хувьцаат компани нэмж хувьцаа гаргасан бол “Бишрэлт индастриэл” ХК, "Дорнод хүнс" ХК, "Монголын гэгээ" ХК, "Азиа пасифик пропертис" ХК, “Монгол мах экспо” ХК-иуд буюу нийт 5 хувьцаат компани нь нийтэд гаргасан хувьцаагаа үнэт цаасны бүртгэлээс хасуулсан байна.

Мөн тайлант хугацаанд “Баянбогд” ХК нь “Стандарт проперти групп” ХХК-тай нэгдэж, компанийн нэрийг “Стандарт проперти групп” ХК болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан байна.

"Дорнод импекс" ХК-ийн үнэт цаасны арилжааг сэргээсэн бол "Шарын гол" ХК-ийн тодорхой хэмжээний хувьцааг бүртгэлээс хассан байна.

"Зоос гоёл" ХК-ийн гаргасан 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 288 ширхэг энгийн хувьцааг нэг бүр нь 28,800 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1 ширхэг энгийн хувьцаанд хөрвүүлэх замаар нэгтгэсэн компанийн нийт гаргасан 3,754,944 ширхэг энгийн хувьцааг 13,038 ширхэг энгийн хувьцаа болгон бүртгэсэн байна.

Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан компаниудын талаарх мэдээллийг хүснэгтлэн харуулбал:

Хүснэгт - 13

| № | Компанийн нэрс | Огноо | Тогтоолын дугаар | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | "БИНСЭ" ХК | 2015.01.28 | 70 | 1 сая хувьцааг нэмж бүртгэсэн. |
| 2 | "Багануур, зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ХК | 2015.01.28 | 71 | 51,664,618 ширхэг хувьцааг нэмж бүртгэсэн. |
| 3 | "Цахилгаан дамжуулах үндсэнмй сүлжээ" ХК | 2015.01.28 | 72 | 1,781,861,267 ширхэг хувьцааг нэмж бүртгэсэн. |
| 4 | "Стандарт проперти групп" ХК /Баянбогд/ | 2015.04.01 | 162 | Баянбогд ХК-ийг "Стандарт проперти групп" ХХК-тай нэгтгэн нэрийг "Стандарт проперти групп" ХК болгон өөрчлөн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан. |
| 5 | "Блюскай секьюритиз" ҮЦК ХК | 2015.05.20 | 243 | 1,805,054 ширхэг хувьцааг нэмж бүртгэсэн. |
| 6 | "Дорнод хүнс" ХК | 2015.05.20 | 256 | Үнэт цаасны бүртгэлээс хассан. |
| 7 | "Дорнод импекс" ХК | 2015.06.24 | 285 | Арилжааг нь сэргээсэн. |
| 8 | "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК | 2015.06.24 | 286 | 221,280,101 ширхэг хувьцааг нэмж бүртгэсэн. |
| 9 | "Монголын гэгээ" ХК | 2015.06.24 | 287 | Үнэт цаасны бүртгэлээс хассан. |
| 10 | "УБ БҮК" ХК | | 288 | 1,775,475 ширхэг хувьцааг нэмж бүртгэсэн. |
| 11 | "Хай Би Ойл" ХК | 2015.07.02 | 302 | 42,884,686 ширхэг хувьцааг нэмж бүртгэсэн. |
| 12 | "Шарын гол" ХК | 2015.07.03 | 308 | ҮЦБ-д өөрчлөлт оруулж 61,147 ширхэгийг хассан. |
| 13 | "Монгол мах экспо" ХК | 2015.07.03 | 309 | Үнэт цаасны бүртгэлээс хассан. |
| 14 | "Бишрэлт индастриэл" ХК | 2015.07.03 | 310 | Үнэт цаасны бүртгэлээс хассан. |
| 15 | "ДБЭХСүлжээ" ТӨХК | 2015.07.03 | 311 | 62,679,220 ширхэг хувьцааг нэмж бүртгэсэн. |
| 16 | "Азиа пасифик пропертис" ХК | 2015.07.10 | 329 | Үнэт цаасны бүртгэлээс хассан. |
| 17 | "Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ" ХК | 2015.8.05 | 334 | 182,194,989 ширхэг хувьцааг нэмж бүртгэсэн. |
| 18 | "Дулааны гуравдугаар цахилгаан станц" ХК | 2015.8.28 | 347 | 621,503,902 ширхэг хувьцааг нэмж бүртгэсэн. |
| 19 | "Зоос гоёл" ХК | 2015.9.25 | 366 | 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 288 ширхэг энгийн хувьцааг нэг бүр нь 28,800 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1 ширхэг энгийн хувьцаанд хөрвүүлэх замаар нэгтгэсэн компанийн нийт гаргасан 3,754,944 ширхэг энгийн хувьцааг 13,038 ширхэг энгийн хувьцаа болгон бүртгэсэн. |

## Ногдол ашиг тараалтын байдал:

Тайлант хугацаанд нэр бүхий 23 хувьцаат компани нийт 199,854,730 ширхэг хувьцаанд ногдох нийт 7,313,698,806.5 төгрөгийн ногдол ашгийг тараахаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

Хүснэгт-14

| Д/д | Компанийн нэрс | Нэгж хувьцаанд тараах ногдол ашгийн мөнгөн дүн | Нийт хувьцааны тоо ширхэг | Ногдол ашгийн нийт дүн | Бүртгэх өдөр | Тараах хэлбэр |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | Тахь Ко | 82 | 1 189 983.0 | 97 578 606.0 | 2015.03.16 | ҮЦТТТХТ |
| **2** | Говь | 140 | 7 801 125.0 | 1 092 157 500.0 | 2015.02.27 | ХК, ҮЦТТТХТ |
| **3** | Монинжбар | 5 | 15 869 233.0 | 79 346 165.0 | 2015.03.03 | ХК |
| **4** | Гермес центр | 4.07 | 78 543 001.0 | 319 670 014.1 | 2015.02.28 | ХК, ҮЦТТТХТ |
| **5** | Бинсэ | 10 | 1 268 320.0 | 12 683 200.0 | 2015.02.26 | - |
| **6** | УБ БҮК | 66 | 1 128 275.0 | 74 466 150.0 | Ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр | ХК |
| **7** | Ариг гал | 42.51 | 3 479 320.0 | 147 905 893.2 | - | - |
| **8** | Эрдэнэт суврага | 5 | 156 054.0 | 780 270.0 | 2015.03.02 | ҮЦТТТХТ |
| **9** | Баянтээг | 100 | 252 608.0 | 25 260 800.0 | 2015.03.14 | ҮЦТТТХТ |
| **10** | Махимпекс | 100 | 3 800 721.0 | 380 072 100.0 | 2015.03.26 | ХК |
| **11** | Талх чихэр | 120 | 1 023 703.0 | 122 844 360.0 | 2015.03.31 | ХК |
| **12** | Газар сүлжмэл | 13196.8 | 65 362.0 | 862 569 241.6 | 2015.02.20 | ХК |
| **13** | Монголын цахилгаан холбоо | 6.0637 | 25 870 276.0 | 156 869 592.6 | 2015.04.02 | ҮЦТТТХТ |
| **14** | Ган хэрлэн | 300 | 99 899.0 | 29 969 700.0 | - | - |
| **15** | Таван толгой | 59 | 52 665 200.0 | 3 107 246 800.0 | 2015.03.09 | ҮЦТТТХТ, ХК |
| **16** | Тавилга | 408 | 122 754.0 | 50 083 632.0 | 2015.04.02 | ҮЦТТТХТ, ХК |
| **17** | Адуунчулуун | 85 | 3 151 304.0 | 267 860 840.0 | 2015.03.27 | ҮЦТТТХТ, ХК |
| **18** | Ган хийц | 100 | 242 464.0 | | 2015.03.05 | ҮЦТТТХТ, ХК |
| **19** | Хөвсгөл алтан дуулга | 221.89 | 113 286.0 | | 2015.03.23 | - |
| **20** | Ачит алкабы | 30 | 74 127.0 | 2 223 810.0 | 2015.03.10 | - |
| **21** | Техник импорт | 300 | 1 446 755.0 | 434 026 500.0 | 2015.03.16 | ХК |
| **22** | Материал импекс | 80 | 1 368 206.0 | | 2015.02.24 | ҮЦТТТХТ |
| **23** | Тавилга | 408 | 122 754.0 | 50 083 632.0 | - | - |
| **НИЙТ** | | | **199 854 730.0** | **7 313 698 806.5** | | |

## Ногдол хувь тараалтын байдал:

Тайлант хугацаанд “Бишрэлт индастриэл” ХК, “Дорнод хүнс” ХК, “Монголын гэгээ” ХК, “Азиа пасифик пропертис” ХК-иуд буюу нийт 4 хувьцаат компани нь Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох хууль, журмын дагуу хүсэлт гаргаж нийтэд гаргасан хувьцаагаа үнэт цаасны бүртгэлээс хасуулсан.

Харин 2015 оны 3 дугаар улирлын байдлаар "ҮЦТТТХТ" ХХК нь 1 хувьцаат компанитай ногдол хувийн гэрээ байгуулж, үйлчилгээний хөлс 667,000 төгрөг тооцож, нийт 1,274 харилцагчийн дансанд 123.9 сая төгрөгийн ногдол хувийн мөнгийг байршуулсан байна.

2014 оны 12 дугаар сарын 08-ны өдөр гэрээ байгуулж, үйлчилгээний хөлсөө төлсөн боловч гэрээнд заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол хувийн дутуу мөнгийг шилжүүлж дууссан тул "Хялганат" ХК-ийн 428 хувьцаа эзэмшигчийн 1,304 ширхэг хувьцаанд ногдох 30,407,428.32 төгрөгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан байна.

Тайлант хугацаанд "ҮЦТТТХТ" ХХК-тай ногдол хувь тараах гэрээ байгуулан ногдол хувь тараасан хувьцаат компаниудын талаарх мэдээллийг хүснэгтлэн харуулбал:

Хүснэгт-15

| № | Компанийн нэрс | Бүртгэх өдөр | Нэгж үнэ | ХЭ-ийн тоо | Хувьцааны тоо | Дансанд байршуулсан мөнгө | Дансанд байршуулсан огноо |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | "ХЯЛГАНАТ" ХК | 2014/10/08 | 23319 | 428 | 1,304 | 30,407,428 | 2015/02/03 |
| 2 | "ДОРНОД ХҮНС" ХК | 2015/05/20 | 760 | 1 274 | 163,019 | 123,894,440 | 2015/05/28 |
| **НИЙТ** | | | | 1 702 | 164,323 | 154,301,868 | |

## Их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцлийн судалгаа

Тайлант хугацаанд "Говь" ХК 20 тэрбум төгрөгийн, "Материал импекс" ХК 10 тэрбум төгрөгийн, "Атар өргөө" ХК 5.37 сая ам.долларын, "Хархорин" ХК 4.04 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус татахын тулд компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөр их хэмжээний хэлцлийг санал нэгтэйгээр шийдвэрлүүлж тус Хорооноос холбогдох тодорхойлолтыг авсан байна. Мөн Улаанбаатар хивс 744.0 сая төгрөгийн зээлийг Хасбанкаас авсан байна.

## Засгийн газрын үнэт цаасны судалгаа:

2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд нийт 4,233,914 ширхэг үнэт цаасыг 403.47 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 12, 28, 52, 156, 260 долоо хоногийн хугацаатай ЗГҮЦ хөрөнгийн биржээр тус тус арилжаалагдсан байна. Энэхүү ЗГҮЦ-ны өгөөжийн муруй дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-16

| Д/д | Хугацаа | Нийт дүн | Жигнэсэн дундаж хүү | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| 1 | 12 долоо хоног | 3,010,510 | 14.860% | 71.10% |
| 2 | 28 долоо хоног | 672,692 | 14.453% | 15.89% |
| 3 | 52 долоо хоног | 550,337 | 14.989% | 13.00% |
| 4 | 156 долоо хоног | 355 | 16.875% | 0.01% |
| 5 | 260 долоо хоног | 20 | 16.750% | 0.00% |
| Нийт | | **4,233,914** | | **100.00%** |

График-11




ЗГҮЦ-ыг хугацааны хувьд ангилахад нийт үнийн дүнд эзлэх хувь дараах байдалтай байна. Үүнд:

График-12




Статистик мэдээллээс үзэхэд 12 долоо хоногтой ЗГҮЦ-ны арилжаа хамгийн их буюу 71.10 хувийг эзэлж байна.

Монголбанкаар арилжаалсан ЗГҮЦ-ыг хугацааны хувьд ангилахад үнийн дүнд эзлэх хувь дараах байдалтай байна. Үүнд:

График-13




Статистик мэдээллээс үзэхэд 12 долоо хоногтой ЗГҮЦ-ны арилжаа хамгийн их буюу 48.76 хувь /585.0 тэрбум төгрөг/-ийг эзэлж байна. Монголбанкаар 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд 12, 28, 52, 156 долоо хоногийн хугацаатай, нийт 1,199.75 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжаалсан байна.

ЗГҮЦ-ны нийт арилжаалагдсан дүн 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 1,603,223.18 тэрбум төгрөг байх бөгөөд Монголбанк болон хөрөнгийн биржээр арилжагдсан ЗГҮЦ-ыг ангилан доорхи хүснэгтээр харуулав. Үүнд:

Хүснэгт-17

| **Огноо** | **Монголбанк** | **"Монголын хөрөнгийн бирж" ХК** | **Нийт** |
|---|---|---|---|
| | Үнийн дүн /сая ₮/ | Үнийн дүн /сая ₮/ | |
| **2015 оны 3 дугаар улирал** | 1,199,750.00 | 403,473.18 | **1,603,223.18** |

Жич: Монголбанкны ЗГҮЦ-ны нэрлэсэн үнэ 1 сая төгрөг, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн ЗГҮЦ-ны нэрлэсэн үнэ 100 мян.төгрөг болно.

Нийт арилжаалагдсан ЗГҮЦ-ны эзлэх хувиар ангилахад Монголбанкаар арилжсан ЗГҮЦ-ны эзлэх хувь 74.83, "Монголын хөрөнгийн бирж" ХК-иар арилжсан ЗГҮЦ-ны эзлэх хувь 25.17 байна.

**Шигтгээ-2:**

- *Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шатанд төрөөс иргэдэд үнэ төлбөргүйгээр хөрөнгө оруулалтын эрхийн бичгийг тарааж, уг эрхийн бичгээр хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдийн хувьцааг эзэмшүүлснээр үнэт цаасны зах зээл дэх хөрөнгө оруулагчийн тогтолцоо бий болсон.*
- *Гэвч үнэт цаасны зах зээлийн талаарх иргэдийн мэдлэг, мэдээлэл дутмаг, мэргэжлийн зуучлагч байгууллагыг ёс зүйгүй үйлдэл, хувьцаат компанийн бүртгэлийн шаардлага хангалтгүй, үнэлгээ хэт доогуур байснаас шалтгаалан цөөн тооны этгээдүүдийн гарт дийлэнх хувьцаат компаниудын хяналтын багц төвлөрч, компанийн засаглал, ил тод байдал, тайлагналын зарчим алдагдагдахад голлох нөлөөг үзүүлсэн.*
- *Тус Хорооны зүгээс Компанийн засаглалын үндэсний зөвлөлтэй хамтран бүртгэлтэй хувьцаат компаниудын засаглалыг сайжруулах, төвлөрлийг сааруулах, 75 хувиас дээш төвлөрөлтэй хувьцаат компаниудыг биржийн бүртгэлээс хасах, төрийн өмчийн компаниудыг биржээр дамжуулан хувьчлах чиглэлд анхаарал хандуулан ажиллаж байна.*

---

## Зохицуулалттай этгээд:

2015 оны 3 дугаар улирлын байдлаар Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий үнэт цаасны компани /ҮЦК/ 62, арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банк 3, хөрөнгө оруулалтын менежментийн 3, нийт 71 зохицуулалттай этгээд үйл ажиллагаа явуулж байна.

Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай этгээдүүдийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт-18

| Д/д | Тусгай зөвшөөрлийн төрлөөр | Зуучлагч байгууллагын тоо |
|---|---|---|
| **1** | Арилжаа эрхлэх | 2 |
| **2** | Төлбөр тооцоо, хадгаламжийн | 1 |
| **3** | Харилцагчийн нэрийн өмнөөс зуучлалын үйлчилгээ үзүүлэх | 11 |
| **4** | Хөрөнгө оруулалтын менежментийн | 3 |
| **5** | Брокер, дилерийн | 62 |
| **6** | Кастодианы үйлчилгээ үзүүлэх | 3 |
| **7** | Давхардсан тоогоор андеррайтерийн | 24 |
| **8** | Давхардсан тоогоор хөрөнгө оруулалтын зөвлөхийн | 15 |
| | **НИЙТ** | **71** |

Хорооны 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 312 дугаар тогтоолоор “Дилерийн арилжааны төв” ХХК-д үнэт цаасны арилжаа эрхлэх, үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Монгол улсын хувьд 2 дахь бирж байгуулагдсан энэхүү үйл явдал нь зах зээлийн өрсөлдөөнийг бий болгож, үйлчилгээний зардлыг бууруулах, ингэснээр зах зээлд оролцогчдод эерэгээр нөлөөлөх давуу талтай байна.

Тайлант хугацаанд “Юнайтед секюритиз ҮЦК” ХХК-ийн брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооны 2015 оны 73 дугаар тогтоолоор түдгэлзүүлж, “Голомт секюритиз ҮЦК” ХХК-д андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2015 оны 156 дугаар тогтоолоор нэмж олгосон. Мөн Хорооны 2015 оны 236 дугаар тогтоолоор “Сикап ҮЦК” ХХК-д хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгосон байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 54.1-д “Зохицуулалттай этгээд нь тухайн санхүүгийн тайлангийн жил дуусах тухай бүр нягтлан бодох болон бусад бүртгэлдээ аудитийн шалгалт хийлгэж, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан хувийг аудитийн дүгнэлтийн хамт Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд Хороонд ирүүлнэ” гэж заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн заавар, маягтын дагуу ҮЦК-иуд 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлан гаргаж, 46 ҮЦК мастер файлын дагуу шивж, Хорооны ФИНА систем рүү илгээсэн бөгөөд мөн цаасан хэлбэрээр баталгаажуулан ирүүлсэн байна.

Үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 71 зохицуулалттай этгээд байгаагаас арилжаа эрхлэх болон төлбөр, тооцоо, төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх 3, кастодиан банкны үйл ажиллагаа эрхлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх 3, нийт 9 компанийн санхүүгийн тайланг нэгтгэлд оруулаагүй болно.

Санхүүгийн тайлангийн нэгтгэлийг 2 төрлөөр гаргасан бөгөөд хавсралт 2 болон хавсралт 3-аар ФИНА системийн дагуу мастер файлаар шивж, цаасаар баталгаажуулан ирүүлсэн нийт 46 ҮЦК-ийн санхүүгийн байдлын болон орлогын дэлгэрэнгүй тайланг, хавсралт-4, хавсралт 5-аар санхүүгийн тайлангаа ирүүлээгүй нийт 16 ҮЦК-ийн Сангийн яамны Е-Балансад хамгийн сүүлд оруулсан санхүүгийн байдлын тайлан болон орлогын дэлгэрэнгүй тайланг нэмж нэгтгэж нийт 62 ҮЦК-ийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийг тус тус гаргасан болно.

### *Ерөнхий санхүүгийн үзүүлэлтүүд:*

ҮЦК-иудын ерөнхий санхүүгийн үзүүлэлтүүдийг тооцохдоо 3 улирал дараалан санхүүгийн тайлангаа Хороонд тогтмол ирүүлсэн 41 ҮЦК-ийн хувьд тооцсон болно.

Хүснэгт-19 /мянган төгрөг/

| № | Үндсэн үзүүлэлтүүд | 15-03-31 | 15-06-30 | 15-09-30 |
|---|---|---|---|---|
| 1 | Тайлан ирүүлсэн | 41 ҮЦК | 41 ҮЦК | 41 ҮЦК |
| 2 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 54 719 760.32 | 36 487 454.27 | 34 971 312.73 |
| 3 | Эргэлтийн бус хөрөнгө | 19 561 208.64 | 18 901 757.60 | 20 329 086.46 |
| 4 | **Нийт актив** | **74 280 967.99** | **55 389 211.87** | **55 300 399.19** |
| 5 | Өр төлбөр | 24 451 865.37 | 5 512 387.01 | 5 380 414.08 |
| 6 | Эздийн өмч | 49 829 102.60 | 49 876 824.86 | 49 919 985.11 |
| 7 | **Нийт пассив** | **74 280 967.99** | **55 389 211.87** | **55 300 399.19** |

Тайлант хугацааны нийт эргэлтийн хөрөнгийн дүн нь 2015 оны эхний улирлын дүнтэй харьцуулвал 36.09 хувиар, 2015 оны эхний хагас жилийн дүнтэй харьцуулвал 4.16 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байгаа бол эргэлтийн бус хөрөнгийн дүн нь 2015 оны эхний улирлын дүнтэй харьцуулвал 3.93 хувиар, 2015 оны эхний хагас жилийн дүнтэй харьцуулвал 7.55 хувиар тус тус өссөн байна.

Тайлант хугацааны нийт өр төлбөрийн дүн нь 2015 оны эхний улирлын дүнтэй харьцуулвал 78.0 хувиар, 2015 оны эхний хагас жилийн дүнтэй харьцуулвал 2.39 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байгаа бол эздийн өмчийн нийт дүн нь 2015 оны эхний улирлын дүнтэй харьцуулвал 0.18 хувиар, 2015 оны эхний хагас жилийн дүнтэй харьцуулвал 0.09 хувиар тус тус өссөн.

Харин тайлант хугацааны нийт актив болон пассивын дүн нь 2015 оны эхний улирлын дүнтэй харьцуулвал 25.55 хувиар, 2015 оны эхний хагас жилийн дүнтэй харьцуулвал 0.16 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

### *Активын бүтэц:*

Нэгтгэлд хамрагдсан нийт 46 ҮЦК-иудын активын бүтэц 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-20 /мянган төгрөг/

| Санхүүгийн байдлын тайлан | ТАЙЛАНТ ҮЕ | Хувь |
|---|---|---|
| Хөрөнгө | **58 752 448.40** | **100.00%** |
| *Эргэлтийн хөрөнгө* | ***38 205 719.25*** | ***65.03%*** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 15 297 214.41 | 26.04% |
| Дансны авлага (цэвэрээр) | 4 055 101.82 | 6.90% |
| Татвар, НДШ-ийн авлага | 11 236.88 | 0.02% |
| Бусад авлага | 1 489 133.05 | 2.53% |
| Санхүүгийн хөрөнгө | 14 755 440.28 | 25.11% |
| Бараа материал | 43 084.16 | 0.07% |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 1 867 469.57 | 3.18% |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 45 054.16 | 0.08% |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | 641 984.92 | 1.09% |
| *Эргэлтийн бус хөрөнгө* | ***20 546 729.15*** | ***34.97%*** |
| Үндсэн хөрөнгө (цэвэрээр) | 5 518 295.94 | 9.39% |
| Биет бус хөрөнгө (цэвэрээр) | 165 784.42 | 0.28% |
| Дуусаагүй барилга | - | 0.00% |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 14 794 788.97 | 25.18% |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 67 859.82 | 0.12% |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | - | 0.00% |

Нэгтгэлд хамрагдсан ҮЦК-иудын нийт актив тайлант үеийн байдлаар 58.75 тэрбум төгрөг байх ба нийт активын 65.03 хувийг эргэлтийн хөрөнгө, 34.97 хувийг эргэлтийн бус хөрөнгө тус тус эзэлж байна.Үүнийг задалж үзэвэл мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нийт активын 26.04 хувийг, авлага 9.45 хувийг, бараа материал 0.07 хувийг, урьдчилж төлсөн зардал/тооцоо 3.18 хувийг, бусад эргэлтийн хөрөнгө 0.08 хувийг, борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө 1.09 хувийг тус тус эзэлж байна.

Эргэлтийн бус хөрөнгийн хувьд үндсэн хөрөнгө /цэвэрээр/ нийт активын 9.39 хувийг, биет бус хөрөнгө /цэвэрээр/ 0.28 хувийг, урт хугацаат хөрөнгө оруулалт 25.18 хувийг, хойшлогдсон татварын хөрөнгө 0.12 хувийг тус тус эзэлж байна.

## Салбарын тайлант улирлын нийт активын бүтцийг харуулбал:

График-14




## *Пассивын бүтэц:*

Нэгтгэлд хамрагдсан нийт 46 ҮЦК-иудын пассивын бүтэц 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дараах байдалтай байна Үүнд:

Хүснэгт-21 /мянган төгрөг/

| Санхүүгийн байдлын тайлан | ТАЙЛАНТ ҮЕ | Хувь |
|---|---|---|
| Өр төлбөр ба эздийн өмч | **58 752 448.40** | **100.00%** |
| Өр төлбөр | **6 572 745.16** | **11.19%** |
| *Богино хугацаат өр төлбөр* | ***6 100 613.76*** | ***10.38%*** |
| Дансны өглөг | 3 766 978.69 | 6.41% |
| Цалингийн өглөг | 100 223.11 | 0.17% |
| Татварын өр | 77 887.75 | 0.13% |
| НДШ-ийн өглөг | 48 463.32 | 0.08% |
| Богино хугацаат зээл | 360 942.13 | 0.61% |
| Хүүний өглөг | -9.17 | 0.00% |
| Ногдол ашгийн өглөг | - | 0.00% |
| Урьдчилж орсон орлого | 57 090.01 | 0.10% |
| Нөөц (өр төлбөр) | 67 731.49 | 0.12% |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 302 711.93 | 0.52% |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр | 1 318 594.51 | 2.24% |
| *Урт хугацаат өр төлбөр* | ***472 131.40*** | ***0.80%*** |
| Урт хугацаат зээл | 272 282.78 | 0.46% |
| Нөөц (өр төлбөр) | - | 0.00% |
| Хойшлогдсон татварын өр | 165.63 | 0.00% |
| Бусад урт хугацаат өр төлбөр (гадаад, дотоодын зах зээлд гаргасан бонд, өрийн бичиг) | 199 683.00 | 0.34% |
| Эздийн өмч | **52 179 703.24** | **88.81%** |
| Өмч | 39 499 817.58 | 67.23% |
| Халаасны хувьцаа | - | 0.00% |
| Нэмж төлөгдсөн капитал | 8 159 697.09 | 13.89% |
| Сангууд | 8 311.57 | 0.01% |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 1 522 685.46 | 2.59% |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | 2 473.52 | 0.00% |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 1 549 040.43 | 2.64% |
| Хуримтлагдсан ашиг, алдагдал | 1 437 677.59 | 2.45% |

Нийт пассив тайлант үеийн байдлаар 58.75 тэрбум төгрөг байх бөгөөд нийт пассивын 11.19 хувийг өр төлбөр, эздийн өм 88.81 хувийг тус тус эзэлж байна. Үүнийг дотор бүтэцээр нь авч үзвэл дансны өглөг нийт пассивын 6.41 хувийг, цалингийн өглөг нийт активын 0.17 хувийг, татварын өр 0.13 хувийг, НДШ-ийн өглөг 0.08 хувийг, богино хугацаат зээл 0.61 хувийг, урьдчилж орсон орлого 0.10 хувийг, урт хугацаат зээл 0.46 хувийг тус тус эзэлж байна.

Эздийн өмчийн хувьд өмч нийт активын 67.23 хувийг, нэмж төлөгдсөн капитал 13.89 хувийг, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 2.59 хувийг, эздийн өмчийн бусад хэсэг 2.64 хувийг, хуримтлагдсан ашиг /алдагдал/ 2.45 хувийг, бусад пассив 3.23 хувийг тус тус эзэлж байна.

**Салбарын тайлант улирлын нийт пассивийн бүтцийг харуулбал:**

График-15




## *Ашигт ажиллагаа, орлого зардлын байдал:*

Тайлант хугацааны санхүүгийн тайлангийн нэгтгэл /нийт 46 ҮЦК/-ийн нийт орлого, зарлага, ашиг, алдагдал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-22 /мянган төгрөг/

| Орлогын дэлгэрэнгүй тайлан 30/09/2015 | Тайлант үе | Хувь |
|---|---|---|
| НИЙТ ОРЛОГЫН ДҮН | **4 207 966.24** | **100.00%** |
| Үйл ажиллагааны орлого | 2 299 175.87 | 54.64% |
| Түрээсийн орлого | 112 502.44 | 2.67% |
| Хүүний орлого | 1 354 663.32 | 32.19% |
| Ногдол ашгийн орлого | 20 006.40 | 0.48% |
| Эрхийн шимтгэлийн орлого | 0.00 | 0.00% |
| Бусад орлого | 421 618.21 | 10.02% |
| Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал | 4 559 144.52 | 108.35% |
| Санхүүгийн зардал | 31 972.43 | 0.76% |
| Бусад зардал | 72 799.70 | 1.73% |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | -117 841.83 | -2.80% |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 62.27 | 0.00% |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 0.00 | 0.00% |
| Бусад ашиг (алдагдал) | -27 772.54 | -0.66% |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | -601 502.51 | -14.29% |
| Орлогын татварын зардал | 98 725.21 | 2.35% |
| Татварын дараах ашиг (алдагдал) | -700 227.72 | -16.64% |
| Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | 0.00 | 0.00% |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | -700 227.72 | -16.64% |

Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал нийт орлогын дүнгээс 8.35 хувиар буюу 351,178.28 мянган төгрөгөөр илүү гарсантай холбоотойгоор 2015 оны 3 дугаар улирлын байдлаар системийн нэгтгэлийн үзүүлэлт 700,227.72 мянган төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Системийн нэгтгэлийн үзүүлэлт алдагдалтай гарахад дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- Нэгтгэлд хамрагдсан 46 үнэт цаасны компаниас нэр бүхий 37 үнэт цаасны компани буюу 80.43 хувь нь алдагдалтай ажилласан ба орлого зардлын харьцаа алдагдсан;

- Нэр бүхий 14 үнэт цаасны компани буюу 30.43 хувь нь 2015 оны 3 дугаар улиралд арилжаанд оролцоогүй, шимтгэлийн орлого олоогүй тул түрээсийн болон ашиглалтын зардал зэрэг тогтмол шинжтэй үйл ажиллагааны зардлуудаас хамааран алдагдал тус тус үүссэн байна.

Хүснэгт-23

| № | Компанийн нэрс | № | Компанийн нэрс |
|---|---|---|---|
| **1** | “Ай трейд ҮЦК” ХХК | 8 | “Зюс капитал ҮЦК” ХХК |
| **2** | “Бага хээр ҮЦК” ХХК | 9 | “Капитал маркет корпораци ҮЦК” ХХК |
| **3** | “Батс ҮЦК” ХХК | 10 | “Лайфтайм инвестмент ҮЦК” ХХК |
| **4** | “Би Би Эс Эс ҮЦК” ХХК | 11 | “Превалент ҮЦК” ХХК |
| **5** | “Говийн ноён нуруу ҮЦК” ХХК | 12 | “Тавантолгой хишиг ҮЦК” ХХК |
| **6** | “Ди Си Эф ҮЦК” ХХК | 13 | “Финанс линк групп ҮЦК” ХХК |
| **7** | “Догсон ҮЦК” ХХК | 14 | “Хүнну Эмпайр ҮЦК” ХХК |

## Нийт арилжааны дүн болон арилжаанд эзлэх хувь /компани бүрээр/

2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүн болох нийт 58 үнэт цаасны компаниудаас 43 компанийн нийт арилжаа нь оны эхнээс өссөн дүнгээр 438,227,406,671 төгрөг байх бөгөөд нийт арилжааны дүн болон эзлэх хувь дараахи байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-24

*2015 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар*

| № | КОМПАНИЙН НЭРС | НИЙТ АРИЛЖАА ДҮН | ЭЗЛЭХ ХУВЬ |
|---|---|---|---|
| **1** | Тэнгэр капитал | 198,803,814,462 | 45.37% |
| **2** | Ти Ди Би Капитал | 89,336,784,887 | 20.39% |
| **3** | Ард капитал групп | 42,759,318,592 | 9.76% |
| **4** | Голомт секюритиз | 38,986,053,236 | 8.90% |
| **5** | БиДиСек | 25,190,348,613 | 5.75% |
| **6** | Монсек | 23,184,869,107 | 5.29% |
| **7** | Дэү Секьюритис Монгол | 5,029,853,440 | 1.15% |
| **8** | Стандарт инвестмент | 4,791,177,084 | 1.09% |
| **9** | Эм Ай Би Жи | 1,880,210,000 | 0.43% |
| **10** | Алтан хоромсог | 1,422,341,566 | 0.32% |
| **11** | Эм Ай Си Си | 1,125,184,246 | 0.26% |
| **12** | Аргай бэст | 921,279,505 | 0.21% |
| **13** | Гацуурт трейд | 578,673,936 | 0.13% |
| **14** | Монгол секюритиес | 552,358,941 | 0.13% |
| **15** | Зэргэд | 423,573,272 | 0.10% |
| **16** | Гендекс | 373,726,104 | 0.09% |
| **17** | Гаүли | 294,283,795 | 0.07% |
| **18** | Бумбат-Алтай | 256,946,833 | 0.06% |
| **19** | СИКАП | 222,028,741 | 0.05% |
| **20** | Булган брокер | 205,691,226 | 0.05% |
| **21** | Дархан брокер | 189,787,689 | 0.04% |
| **22** | Санар | 185,357,429 | 0.04% |
| **23** | Блүмсбюри секюритиес | 167,883,221 | 0.04% |
| **24** | Таван богд | 139,336,837 | 0.03% |
| **25** | Масдак | 135,795,542 | 0.03% |
| **26** | Азиа Пасифик секьюритис | 126,759,149 | 0.03% |
| **27** | Дэлгэрхангай секюритиз | 118,126,619 | 0.03% |
| **28** | Фронтиер | 109,900,952 | 0.03% |

| | | | |
|---|---|---|---|
| **29** | Гүүдсек | 98,849,391 | 0.02% |
| **30** | Тулгат чандмань баян | 90,934,856 | 0.02% |
| **31** | Нэйшнл сэкюритис | 73,167,396 | 0.02% |
| **32** | ACE энд T Капитал | 70,775,943 | 0.02% |
| **33** | Мэргэн санаа | 69,014,351 | 0.02% |
| **34** | Евразиа капитал монголиа | 66,678,729 | 0.02% |
| **35** | Өндөрхаан инвест | 54,584,681 | 0.01% |
| **36** | Монет | 53,152,448 | 0.01% |
| **37** | Эм Даблью Ти Эс | 43,384,286 | 0.01% |
| **38** | Зэт жи би | 29,956,854 | 0.01% |
| **39** | BLUE SKY | 29,799,403 | 0.01% |
| **40** | Эс Жи Капитал | 26,194,880 | 0.01% |
| **41** | Гранддевелопмент | 5,288,275 | 0.00% |
| **42** | Эф Си Икс | 4,137,900 | 0.00% |
| **43** | Блэкстоун интернэйшнл | 22,254 | 0.00% |
| **44** | Батс | 0 | 0 |
| **45** | Би Би Эс Эс | 0 | 0 |
| **46** | Бага хээр | 0 | 0 |
| **47** | Капитал маркет корпораци | 0 | 0 |
| **48** | Ди Си Эф | 0 | 0 |
| **49** | Догсон | 0 | 0 |
| **50** | Финанс линк групп | 0 | 0 |
| **51** | ГОВИЙН НОЁН НУРУУ | 0 | 0 |
| **52** | Хүннү эмпайр | 0 | 0 |
| **53** | Ай трейд | 0 | 0 |
| **54** | Лайфтайм инвестмент | 0 | 0 |
| **55** | Новел инвестмент | 0 | 0 |
| **56** | Превалент | 0 | 0 |
| **57** | Таван Толгойн Хишиг | 0 | 0 |
| **58** | Зюс капитал | 0 | 0 |
| **Нийт** | | **438,227,406,671** | **100.00%** |

Дээрх хүснэгтээс үзэхэд 2015 оны 3 дугаар улирлын байдлаар арилжаанд нэр бүхий 15 үнэт цаасны компани огт оролцоогүй байх бөгөөд нэр бүхий 7 үнэт цаасны компани нийт арилжааны 1 хувиас дээшхийг гүйцэтгэсэн байна. Үүнийг графикаар харуулбал.

График-16



**Хамгийн их ЗГҮЦ-ны арилжаа хийсэн**

Хүснэгт-25

| Д/д | БДК-ийн симбол | БДК-ийн нэр | Нийт үнийн дүн |
|---|---|---|---|
| 1 | TNGR | Тэнгэр капитал | 198,624,400,000 |
| 2 | TDB | Ти Ди Би Капитал | 89,257,300,000 |
| 3 | ARD | Ард капитал групп | 41,822,800,000 |
| 4 | GLMT | Голомт секюритиз | 38,017,500,000 |
| 5 | MSEC | Монсек | 22,890,500,000 |
| 6 | BDSC | БиДиСек | 17,758,200,000 |
| 7 | BZIN | Дэу Секьюритис Монгол | 5,004,200,000 |
| 8 | STIN | Стандарт инвестмент | 3,782,700,000 |
| 9 | MIBG | Эм Ай Би Жи | 1,844,200,000 |
| 10 | ALTN | Алтан хоромсог | 1,298,800,000 |

**Хамгийн их хувьцааны арилжаа хийсэн**

Хүснэгт-26

| Д/д | БДК-ийн симбол | БДК-ийн нэр | Нийт үнийн дүн |
|---|---|---|---|
| 1 | BDSC | БиДиСек | 22,073,779,349 |
| 2 | APS | Азиа Пасифик секьюритис | 7,337,006,749 |
| 3 | ARD | Ард капитал групп | 936,507,322 |
| 4 | STIN | Стандарт инвестмент | 878,506,226 |
| 5 | MONG | Монгол секюритиес | 552,358,941 |
| 6 | GNDX | Гендекс | 371,927,104 |
| 7 | ZRGD | Зэргэд | 335,734,179 |
| 8 | TCHB | Тулгат чандмань баян | 313,556,768 |
| 9 | BUMB | Бумбат-Алтай | 255,846,833 |
| 10 | BULG | Булган брокер | 205,664,138 |

## Хөдөө аж ахуйн биржийн арилжаа, төлбөр тооцооны үзүүлэлтүүд:

“Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК нь 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд нийт 403.9 тэрбум төгрөгийн арилжааг хийсэн байна. Тус бирж нь 2015 оны эхнээс 3 дугаар улирлын эцсийн байдлаар нийт 146 удаагийн арилжаа зохион байгуулж 1,876 хэлцэлээр 6,611 тонн ноолуур, 7,714 тонн хонины ноос 369 тонн тэмээний ноос, 914 тонн ямааны завод ноос, 700 тонн хонины завод ноос / тэмээний/, 19 тонн тэмээний завод ноос 1,576 тонн хүнсний буудай тус тус арилжиж нийт 403.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Хөдөө аж ахуйн бирж дээрх 2015 оны 3 дугаар улирлын байдлаар түүхий эдийн арилжааны үнийн дүн (төгрөг)

Хүснэгт-27

| № | Арилжаалагдсан бараа, түүхий эд | хэмжээ /тонн / | Үнийн дүн |
|---|---|---|---|
| 1 | Ноолуур | 6,611 | 367,894,228,600 |
| 2 | Хонины ноос | 7,714 | 13,379,169,000 |
| 3 | Тэмээний ноос | 369 | 2,036,750,000 |
| 4 | Ямааны завод ноос | 914 | 18,871,203,000 |
| 5 | Хонины завод ноос | 700 | 839,520,000 |
| 6 | Тэмээний завод ноос | 19 | 47,500,000 |
| 7 | Хүнсний буудай | 1,576 | 872,610,000 |
| | **Нийт** | **17,903** | **403,940,980,600** |

График-17




Тус бирж нь 2015 оны 3 дугаар улирлын байдлаар шууд арилжих /спот/ гэрээгээр бараа, түүхий эдийн арилжааг явуулсан байна.

Тайлант үеийн байдлаарх Хөдөө аж ахуйн биржийн нийт арилжааны хэмжээг өмнөх оны мөн үедтэй харьцуулан дараах графикаар харуулав.

График-18




Биржийн нийт арилжаа арилжааг 2014 оны мөн үетэй харьцуулхад 22.04 хувиар бага байна. Энэ нь өмнөх өвөл манай орны нийт нутгаар дулаан байсантай холбоотой голлох бараа ноолуурын ургалт муу, ширхэг богино байсан тул нэгжээс гарах түүхий эдийн хэмжээ бага, зах зээлийн үнэ ханш, үнэлгээ муу байхад нөлөөлсөн байна. Иймд түүхий эдийн чанар, бэлтгэлийн хэмжээнээс шалтгаалж нийт арилжааны хэмжээ мөн бага байхад нөлөөлсөн гэсэн дүгнэлт өгч болохоор байна.

Харин 2015 оны хавраас эхэлж биржээр Хүнсний буудай арилжаалж эхэлсэн ба 2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар ургац хураалт бүрэн дуусч, арилжаа идэвхижээгүй байсан тул арилжааны хэмжээ төдийлэн их байсангүй. Намрын ургац хураалт бүрэн дуусч худалдан авалтууд хийгдэж эхлэх үе буюу 2015 оны 4 дүгээр улиралд хүнсний буудайны арилжааны арилжаа идэвхижиж, тэр хэмжээгээр тус биржийн арилжааны хэмжээ нэмэгдэх эрэг хүлээлт байна. Цаашид биржээр арилжаалагдах бараа, түүхий эдийн төрлийг олшруулах шаардлагатай байна.

Тус бирж дээр 2015-2016 онуудад бараа, түүхий эдэд суурилсан нэг загварын гэрээ /фьючерс/-ний арилжааг эхлүүлэхээр биржийн зүгээс холбогдох бэлтгэл ажлуудыг хангасан ба арилжааны цахим систем /платформ/-ийг худалдан авах санхүүжилт түр саатсантай холбоотой уг ажил эхний хагас жилийн байдлаар хэрэгжиж эхлээгүй байна.

## Кастодиан банкны тухай:

Тайлант хугацаанд "Хаан банк" ХХК нь кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус Хорооноос 6 дугаар сард гардан авсан байна. 2015 хагас жилийн байдлаар тус Хорооноос кастодианы тусгай зөвшөөрөл авсан нийт 3 банк үйл ажиллагаагаа явуулж байна. Хүснэгтлэн харуулбал:

Хүснэгт-28

| № | Компанийн нэрс | Тогтоол-ын огноо | Тогтоолын дугаар |
|---|---|---|---|
| 1 | ГОЛОМТ БАНК | 2014.08.27 | 295 |
| 2 | ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК | 2014.10.21 | 388 |
| 3 | ХААН БАНК | 2015.06.24 | 284 |

## Хөрөнгө оруулалтын сангийн тухай:

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан бөгөөд 2015 оны хагас жилийн байдлаар ямар нэгэн хөрөнгө оруулалтын сан үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй байна.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсны дагуу тус Хорооноос хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын санг хэрхэн үүсгэн байгуулах, хэрхэн тусгай зөвшөөрөл олгох тухай журам, зохицуулалтыг батлан, эрх зүйн орчныг илүү боловсронгүй болгосон бөгөөд өнөөдрийн байдлаар нэр бүхий 3 компани хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус Хорооноос аваад байна.

## Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн тухай:

Хүснэгт-29

| № | Компанийн нэрс | Тогтоол-ын огноо | Тогтоол-ын дугаар |
|---|---|---|---|
| 1 | "ЭКСПОНЭЙНШЛ ФАНД МЕНЕЖМЕНТ" ХХК | 2014.04.23 | 129 |
| 2 | "БОДЬ ИНВЕСТ" ХХК | 2014.05.21 | 173 |
| 3 | "ВИРТУС АССЕТ МЕНЕЖМЕНТ" ХХК | 2014.12.10 | 433 |

## Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө өгөх, хөрөнгийн үнэлгээ хийх, аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй зохицуулалттай этгээдүүдийн талаарх мэдээлэл:

2015 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй үнэт цаасны зах зээлд оролцогчдод аудитын, үнэлгээний, хуулийн үйлчилгээ үзүүлэх нийт 69 компани байна. Үүнд:

Хүснэгт-30

| № | Үйл ажиллагааны чиглэл | Байгууллагын тоо |
|---|---|---|
| 1 | Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх аудитын компани | 34 |
| 2 | Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх үнэлгээний компани | 20 |
| 3 | Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх хуулийн компани | 15 |
| | **НИЙТ** | **69** |

## Өөрийгөө зохицуулах байгууллагатай холбоотой:

Монгол улсын хамгийн анхны өөрийгөө зохицуулах байгууллагаар Хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 273 дугаар тогтоолоор "МҮЦАЭХ" ТББ бүртгэгдсэн.

Өөрийгөө зохицуулах байгууллага нь зохицуулалттай хуулийн этгээд болон үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх авсан мэргэжилтнүүдээс бүрдсэн гишүүнчлэлтэй, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагаа болон ёс зүйн нийтлэг журмыг тогтоох, гишүүдийнхээ чадавхыг дээшлүүлэх, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилготой билээ.

Өөрийгөө зохицуулах байгууллага бий болсноор төр, хувийн хэвшлийн түншлэл сайжрах, зах зээлийн хяналт нэмэгдэх, мэргэжлийн оролцогчдын ёс зүй сайжрах давуу талуудтай байна. Мөн "Монголын хөрөнгийн бирж" ХК нь Хорооны 2014 оны 252 дугаар тогтоолоор батлагдсан "Өөрийгөө зохицуулах байгууллагын бүртгэх тухай журам"-ын дагуу бүртгүүлэх хүсэлт болон холбогдох материалыг тус Хороонд ирүүлээд байна.

### Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотой:

Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10-р сарын 22-ны өдөр байгуулсан "Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгч, Барилга, хот байгуулалтын сайдын 2013 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А-2/06 тоот тушаалаар "Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах" дэд хөтөлбөрийг баталсан.

Энэхүү дэд хөтөлбөрт ипотекийн хоёрдогч захыг хөгжүүлэх эхний үе шатанд санхүүгийн эх үүсвэрээр хангах, ипотекийн хоёрдогч захад үйл ажиллагаа явуулах үндсэн санхүүгийн байгууллагыг бодлого зохицуулалтаар дэмжих арга, хэрэгслээр 3 жилийн хугацаанд, 800.0 тэрбум төгрөгийн санхүүжилттэй хэрэгжүүлэх "Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр" багтсан.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан "Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг"-т "Монголбанкны эзэмшиж байгаа ипотекоор баталгаажсан үнэт цаастай тэнцэх хэмжээний урт хугацаат үнэт цаасыг Засгийн газар эдийн засгийн чадавхид тулгуурлан нийгмийн даатгалын санг дахин хөрөнгөжүүлэх зорилгоор хэсэгчлэн гаргана.

Засгийн газар Монголбанкны эзэмшиж байгаа ипотекоор баталгаажсан үнэт цаасыг дахин хөрөнгөжсөн Нийгмийн даатгалын сангийн активт хөрвүүлнэ. Мөн Монголбанк ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох эхлэлийн санхүүжилтийг шийдвэрлэнэ" гэж тусгасан.

Эдгээр санамж бичиг, хөтөлбөрүүдийн хүрээнд Монголбанкнаас "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам" баталж, мөн Монголбанк, арилжааны банкууд, "МИК ОССК"-ийн хооронд "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн ерөнхий гэрээ"-г байгуулсан байна.

Гэрээнд Монголбанк ипотекийн хоёрдогч захад суурилсан орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор эхлэлийн санхүүжилтийг "Монголбанкнаас банкинд олгох орон сууцны ипотекийн санхүүжилтийн гэрээ"-г байгуулан олгох, банк нь орон сууцны ипотекийн зээлийг "МИК ОССК"-иас үүсгэн байгуулсан ТЗК-д худалдах, тухайн ТЗК-иас гаргасан ИЗББ-ыг худалдан авах хэлцлийг МИК болон банкны хооронд байгуулах гэрээний дагуу хийнэ гэх зэрэг ерөнхий зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагын талаар тусгасан.

Дээрх хөтөлбөрүүд, санамж бичиг болон гэрээний хүрээнд орон сууцны зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах ажлыг гүйцэтгэхэд эрх зүйн зохицуулалт, дүрэм журамд өөрчлөлт оруулах, шинээр журам тогтоох шаардлага үүссэн.

Монголбанк болон "МИК ОССК"-ийн зүгээс Хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-д өөрчлөлт оруулах саналыг ирүүлсэн бөгөөд Хорооны зүгээс уг журамд нэмэлт,

өөрчлөлт оруулах төслийг бэлтгэж, Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, холбогдох өөрчлөлтийг оруулсан.

Эдгээр эрх зүйн орчин бүрдсэнээр “МИК ОССК” ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах зорилго бүхий өөрийн бүрэн эзэмшлийн тусгай зориулалтын компаниудыг үүсгэн байгуулж, Хорооноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны болон хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл авсан байна.

Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөл бүхий 6 тусгай зориулалтын компаниуд нь нийт 42,374 зээлдэгчийн зээлийн хөрөнгөөр баталгаажсан 1,909,926,500,000 төгрөгийн үнэ бүхий баталгаат үнэт цаас гаргасан. 2015 оны 9-р сарын 30-ны өдрийн байдлаар нийт 111,080,300,000 төгрөгийн үндсэн төлбөр төлөгдсөн байна.

Хүснэгт-31

| **Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас** | | | |
|---|---|---|---|
| **Үнэт цаас гаргагч** | Нийт гаргасан баталгаат үнэт цаас /тэрбум төгрөг/ | "ҮЦТТХТ" ХХК-д бүртгэсэн үнэт цаас /тэрбум төгрөг/ | Зээлдэгчдийн тоо /мянга/ |
| **“МИК актив нэг ТЗК” ХХК** | 328.1 | 322.9 | 7.9 |
| **“МИК актив хоёр ТЗК” ХХК** | 224.8 | 222.05 | 5.9 |
| **“МИК актив гурав ТЗК” ХХК** | 328.5 | 324.6 | 7.1 |
| **“МИК актив дөрөв ТЗК” ХХК** | 459.4 | 452.3 | 9.9 |
| **“МИК актив тав ТЗК” ХХК** | 301.2 | 294.3 | 5.9 |
| **“МИК актив зургаа ТЗК” ХХК** | 267.8 | 261.7 | 5,258 |
| **Нийт** | **1,909.8** | **1,877.9** | **5,294.7** |

Хүснэгт-32

| **№** | **Компанийн нэрс** | | **Хорооны тогтоолын дагуу** | | **"ҮЦТТХТ" ХХК бүртгэсэн** | **2015.09.30-ны өдрийн байдлаарх үлдэгдэл** | **Төлөгдсөн үндсэн төлбөр** |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | **“МИК актив нэг ТЗК” ХХК** | Нийт гаргасан баталгаат үнэт цаасны дүн /төгрөгөөр/ | **328,146,500,000 төгрөг хүртэл** | **2013.12.16-ны өдрийн 512** | **322,901,700,000** | **269,431,200,000** | **53,470,500,000** |
| | | Зээлдэгчдийн тоо | **7,917** | | **7,853** | **6,989** | |
| 2 | **“МИК актив хоёр ТЗК” ХХК** | Нийт гаргасан баталгаат үнэт цаасны дүн /төгрөгөөр/ | **224,836,200,000 төгрөг хүртэл** | **2014.06.25-ны өдрийн 243** | **222,051,700,000** | **202,177,600,000** | **19,874,100,000** |
| | | Зээлдэгчдийн тоо | **5,937** | | **5,898** | **5,495** | |
| 3 | **“МИК актив гурав ТЗК” ХХК** | Нийт гаргасан баталгаат үнэт цаасны дүн /төгрөгөөр/ | **328,548,600,000 төгрөг хүртэл** | **2014.10.21-ний өдрийн 386** | **324,595,800,000** | **306,738,100,000** | **17,857,700,000** |
| | | Зээлдэгчдийн тоо | **7,105** | | **7,059** | **6,814** | |
| 4 | **“МИК актив дөрөв ТЗК” ХХК** | Нийт гаргасан баталгаат үнэт цаасны дүн /төгрөгөөр/ | **459,372,600,000 төгрөг хүртэл** | **2015.01.14-ний өдрийн 18** | **452,278,100,000** | **436,921,500,000** | **15,356,600,000** |
| | | Зээлдэгчдийн тоо | **10,034** | | **9,961** | **9,753** | |
| 5 | **“МИК актив тав ТЗК” ХХК** | Нийт гаргасан баталгаат үнэт цаасны дүн /төгрөгөөр/ | **301,213,000,000 төгрөг хүртэл** | **2015.03.14-ний өдрийн 18** | **294,343,300,000** | **289,490,900,000** | **4,521,400,000** |
| | | Зээлдэгчдийн тоо | **6,052** | | **5,997** | **5,945** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **6** | **“МИК актив зургаа ТЗК” ХХК** | Нийт гаргасан баталгаат үнэт цаасны дүн /төгрөгөөр/ | **267,809,600,000 төгрөг хүртэл** | **2015.08.05-ны өдрийн 337** | **261,699,200,000** | **261,699,200,000** | - |
| | | Зээлдэгчдийн тоо | **5,329** | | **5,227** | **5,258** | |

***Шилтгээ-3:***

- *Үнэт цаасны зах зээлийн талаар хөгжингүй орнуудын туршлагаас харахад банк, түүний охин, хараат компаниудад брокер, андеррайтер, кастодиан, хөрөнгө оруулалтын сан, менежментийн үйл ажиллагаа эрхлэхэд таатай эрх зүйн орчин бүрдүүлснээр зах зээлийн зуучлалын үйлчилгээг гүнзгийрүүлж, улмаар зээл, хадгаламжийн хүүгийн түвшинг бууруулжээ.*
- *Манай орны хувьд Банкны тухай хуулийн 6.2 дахь хэсэгт банк, түүний охин, хараат компани Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэйгээр нэр бүхий 7 үйлчилгээг үнэт цаасны болон даатгалын зах зээлд эрхлэхээр зохицуулагдсан байдаг.*
- *Өнөөгийн манай улсын санхүүгийн зах зээлийн 90-ээс дээш хувийг банкны салбар эзэлж байгаа нөхцөлд үнэт цаас, даатгалын салбар дах банкны оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийг өсгөх боломжтой.*

## 2.4. Үнэт цаасны зах зээлийн дэд бүтэц, зохицуулалт:

Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн үр ашигтай, найдвартай, хурдан шуурхай байдал нь хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлд, хөгжилд голлогч нөлөөллийг үзүүлдэг. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн бирж дээр хийгдсэн хэлцлийн дүнд үнэт цаасны өмчлөх эрх, мөнгөн хөрөнгө хурдан шуурхай шилжүүлэх асуудал зах зээлийн дэд бүтцийн уялдаа, технологийн хөгжлөөс ихээхэн хамаардаг.

1995 оноос үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хийгдэж эхэлсэн бөгөөд 2012 оны 7 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд “Бодь” ХХК-ийн охин компани “ECM” ХХК-ийн боловсруулсан арилжаа, төлбөр, тооцоо, хадгаламжийн програм хангамжийг ашиглаж байсан.

2012 оны 7 дугаар сарын 02-ны өдрөөс “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦТТХТ” ХХК-д арилжаа, тооцоо, хадгаламжийн MIT системийг албан ёсоор ашиглаж эхэлсэн. MIT систем нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдын ажиллагааг дэмжисэн, их хэмжээний хэлцлийг нэг зэрэг, цаг хугацааны хоцролтгүй биелүүлэх, маржин ба зээлээр үнэт цаас худалдах, худалдан авах, кастодианы дэд програмыг агуулснаараа давуу талтай.

**Зураг-1. Өнөөгийн үнэт цаасны зах зээлийн дэд бүтэц:**






Гэвч үнэт цаасны арилжааны тооцооны бие даасан дундын зуучлалын үйлчилгээ манайд бий болоогүй, нэгдсэн програм хангамжийг хөгжүүлж чадахгүй байгаагаас санхүүгийн үүсмэл хэрэгсэл болон зээлээр үнэт цаас худалдах, худалдан авах маржин арилжааг бий болгоход шаардлагатай үнэт цаасны төлбөр тооцооны баталгаажуулалтад бэрхшээл үүсч байна.

Засгийн газрын 2015 оны 147 дугаар тогтоолоор "ҮЦТТТХТ" ХХК-ийг төлбөр тооцооны, төвлөрсөн хадгаламжийн чиглэлээр 2 тусдаа бие даасан байгууллага бий болгохоор шийдвэрлэсэн бөгөөд цаашид үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн уялдаа холбоог сайжруулахад арилжааны тооцооны чиглэлээр байгуулагдах шинэ байгууллагыг Үндэсний цахим гүйлгээний үндэсний төвд түшиглэн бие даасан дундын зуучлалын төвийг шинээр байгуулах, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийг өөрийгөө зохицуулах байгууллагын хэлбэрт шилжүүлэх, хувьчлах нь зүйтэй байна.

Бие даасан дундын зуучлалын төвийн үйл ажиллагааг идэвхжүүлэн үнэт цаас, хөдөө аж ахуйн, уул уурхайн биржүүдийн арилжааны тооцоог гүйцэтгэх чиглэлд өргөтгөх, кастодианы үйлчилгээг бүрэн нэвтрүүлэх зэрэг дэд бүтцийн ажлын уялдааг хангах талаар ажиллах шаардлага бий болоод байна.

Цаашдын дэд бүтцийн хандлагыг схемээр үзүүлбэл:

**Зураг-2. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн хандлага**




# II БҮЛЭГ: ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТӨД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

## 2.1. Үнэт цаасны зах зээл:

Манай орны эдийн засагт банкны салбарын зуучлалын үүрэг оролцоо үнэт цаасны зуучлалаас илүү хөгжсөн тул хөрөнгө оруулалтын урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэр дутагдалтай, үнэт цаасны зах зээлийн эдийн засгийн бодит өсөлтөд үзүүлэх нөлөөлөл сул байна.

Монгол улсын үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүдийг тооцох, түүнд нөлөөлөгч макро эдийн засгийн болон бодлогын хувьсагчуудын харилцан хамаарлыг тогтоох чиглэлээр нарийвчилсан судалгаа, шинжилгээний ажлууд өмнө хийгдэж байгаагүй. Тиймээс үнэт цаасны зах зээлийг зохицуулах чиг үүрэг бүхий байгууллагын хувьд үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үзүүлэлтийн харилцан уялдаа судалгаа, шинжилгээ, эконометрикийн арга, аргачлалыг ашиглан хөгжлийн бодлогоо тодорхойлох, уг бодлогод нийцүүлэн үйл ажиллагаагаа төлөвлөх зайлшгүй шаардлага тулгараад байна.

Хөгжингүй орнуудын туршлагаас харахад зах зээлийн үнэлгээний дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 100-аас дээш хувийг эзэлдэг ба энэ нь үнэт цаасны зах зээлд эргэлдэж буй капиталын хэмжээ нь нийт эдийн засгийн гарцын хэмжээнээс өндөр болохыг илтгэж, урт хугацааны эдийн засгийн өсөлтийг голлон тодорхойлогч болдог.

Үнэт цаасны зах зээл нь урт хугацаандаа эдийн засгийн өсөлтөд дараах 3 үндсэн сувгаар дамжин нөлөөлдөг.

- Үнэт цаасны зуучлалаар дамжуулан сул чөлөөтэй хуримтлалыг үр ашигтай хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтэд хуваарилдаг;
